

## ҮНДЭСНИЙ ҮЗЛИЙН ТУХАЙ НИШИДА КИТАРОГИЙН ҮЗЛЭЭС

Д.Оюунгэрэл (Ph.D)

МУИС. НШУС.

Философиийн Тэнхим

**Тулхүүр үз: Өрнө болон дорно, өрсөлдөгч соёл, үндэсний соёл, шинэчлэл, орчин үежүүлэх, хариуцлага**

**Төвч утга:** Ниишида Китарогийн философиийн гол онцлог нь тэрээр үзэл санаагаа дорнын соёлын өвөрмөц шинж байдалд тулгуурласан. Өрнөдөд танигдаагүй соёлын ертөнцийг таниулах явдлыг тэрээр чухалчилж, дорнын соёлын нөлөөг дээшилүүлэхийг зорьж байсан нь сайшаалтай хэрэг юм. Энэ нь түүний үндэсний үзлийн нэгэн илрэл болдог билээ. Тиймээс хүний дотоод ертөнц рүү хандсан дорнын мэргэдийн нэг Ниишида Китарогийн үзэл сургаал бол өнөө цагийн хүмүүсийн амьдралаа зөв жолоодон авч явах нэгэн чухал үзэл болно.

1712 онд японы эрдэмтэн Кайбара Эккен (1630-1714) “Цаг үе, газар орон, нөхцөл байдал” гэдэг бүтээл гаргаж, түүний “бусдыг дууриаж хэрэглэх бус, хувирган тааруулж хэрэглэ” гэсэн зарчим бодит амьдралд хэрэгжиж эхэлсэн байна. Энэ бол европ төвт онол, үзэл санааг шууд хуулбарлан дууриах бус, харин түүний ололт амжилтыг зөв чадварлаг ашиглахыг уриалсан хэрэг байв. Энэ үзэл санааг бодит амьдралд хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан нийгмийн зүтгэлтэн Токугава Ёшинобу (1827-1913) нь улс орныхоо бодит нөхцөл байдлыг түүхийн үүднээс задлан шинжилж, хуучин тогтолцооны хямрал зөрчлийн уг үндсийг олж харж, “Токугава овгийн төр барих эрхийг халья. Өнөөгийн шинэ бодит нөхцөлд тохирсон улс орныг өөр замаар хөгжүүлэх шинэ тогтолцоо хэрэгтэй байна” хэмээн уриалж, улмаар япончууд шёогүнээс татгалзсан билээ.

Шёогүний засаглалын улмаас японы ард түмэн олон жилийн туршид “хаалттай орон”<sup>1</sup> байж, өрнөдийн соёлоос тусгаарлагдаж ирсэн билээ. Гэвч 1853 оны 6 дугаар сард коммодор Перри<sup>2</sup> болон түүний удирдсан үхэр буутай онгоцууд Урага боомтын Ёкохамагийн эрэгт тулж ирсэн бөгөөд Япон улсыг үүд хаалгаа нээхийг шаардсан байна. Тухайн үед япончууд барууны түрэмгийллийн хохирогч болох, аль эсвэл өөрийгөө хамгаалан улс орноо аврахын тулд “нээлттэй орон” болж, орчин үежсэн шинэчлэлийг хүлээн авч нэвтрүүлэх гэсэн хоёр салаа замын нэгийг сонгох асуудалтай тулгарсан юм. Япончууд хоёрдахь замыг нь сонгож, 1868 оны Мейжийн хувьсгал хийсэн бөгөөд энэ нь тэдэнд айdas төрүүлж байсан тэр шинэчлэгдсэн нийгэм нь технологи, улс төр, эдийн засаг, шашин, боловсрол зэрэг олон салбар хөгжих эхлэлийг тавьсан юм.

Мейжийн хувьсгалын дараах японы нийгэм нь “өрнөжих үзэл”, “орчин үежүүлэх үзэл” зэрэг олон янзын үзэл бодлын тэмцлийн түүх байсан гэж хэлэхэд хилсдэхгүй. Эхэн үедээ хүмүүс нийгэмд гарсан өөрчлөлт, гадны нөлөөг эсэргүүцэн дургүйцээ илэрхийлж байв. Гэсэн хэдий ч ард олонд шинэ, орчин үежсэн улс байгуулах, мөн хуучин системээс ангижрах

1. Хаалттай орны бодлого-Эдогийн үе (1603-1868)-д хэрэгжсэн японыг гадаад орноос тусгаарласан бодлого

2. Коммодор (усан цэргийн I зэргийн ахмад) Матеу Килбрейт Перри (1794-1858) Америкийн усан онгоцыг удирдан японд иржээ.

талаар шинэ засгийн газрын улс төрийн лидерүүд идэвхтэй сурталчилгаа хийж байсан гэдэг. “Өрнө болон дорно” гэсэн нэр томъёо нь бараг бүх талын харилцаа, амьдралын хэв маягт гүн шингэсэн байлаа.

Улс төрийн элитүүд япон хэмээгдэх орчин үеийн үндэстний улсыг хэрхэн бий болгох вэ гэдэг талаар ихэд маргалдаг байжээ. Тэр үед боловсролыг шинэчлэгчид шинжлэх ухаан болон уламжлал, ёс заншлын хоорондох тэнцвэрийг хянах шаардлагатай гэж үзэж байлаа. Ийнхүү тэд хөгжлийн асуудлыг тал бүрээ нь нухацтай авч хэлэлцээр ХХ зуунтай золгожээ.

1930, 1940-өөдөн оны үед ч японы нийгмийн болон философиин салбарт ихээхэн өөрчлөлт хөдөлгөөнтэй он жилүүд байсан юм. Өрнийн соёлын нөлөө япон хүмүүсийн сэтгэхүй, нийгмийн амьдралдуурьд омноохөөсөө илүү хүчтэй нөлоолох болсон юм. Түүхийн энэ үеэс азийн боловсрол болон соёлын амьдралд “өрнөжих”, “орчин үежсэн” гэсэн утгатай үг өргөнөөр хэрэглэгдэх болсон бөгөөд японы зарим сэхээтнүүд өрнийн соёлын эсрэг зогсож байлаа.

Энэ үед дэлгэрч байсан өрнийн философиийн үзэл баримтлал нь дайны үед сэргэж, тухайн үед хүчээ авч байсан үндэсний үзэлтэй өрсөлдөн гарч ирсэн юм. Тиймээс өрнийн философиийг сурталчилсан хэмээн Нишида Китарогийн үзэл санааг японы онцлог, үндэсний үзэлд төдийлэн нийцэхгүй гэж зарим философичид үзэж байв. Учир нь Нишида Китаро өрнийн философиийг анхааран судалж, сурталчилж байжээ.

Гэхдээ тэрээр зөвхөн өрнийн философиийг “шүтэгч” биш байсан. Үүний тод жишээ бол нэгэн цаг үе дор ажиллаж амьдарч байсан соён гэгээрүүлэгч Фүкузава Юкичигийн<sup>3</sup> дэвшүүлсэн “Улс орноо сүртэй болгох нэг арга бол өрнөдийн ном зохиолыг аль болох их уншиж судлах явдал” хэмээснийг сайшааж, “Манай улс мэйжийн эринээс хойш өрнийн соёлыг тууштай нэвтрүүлсэн. Европын соёл боловсролыг япончилж, тэдгээрийг хүлээн зөвшөөрч, өөрийн багаж зэвсэг болгон ашиглахыг бодож байж магадгүй. Гэвч тэдгээр нь өөр өөрийн гэсэн ухамсар, үзэл санаатай байдаг.

Тиймээс бид тэрхүү ухамсар, үзэл санаанд нь тулгуурлан өөрсдийн болгож ашиглахгүй бол болохгүй”<sup>4</sup> хэмээн үзэж байсан нь өөрсдийн соёлыг дээшлүүлэхийн тулд өрсөлдөгч соёлоо мэддэг байх, улмаар үндэсний соёлын давуу талыг чухалчилсан санааг илэрхийлсэн гэж хэлж болно. Тэрээр дорнын философиийг өрнийн философиор дамжуулан илэрхийлэх, өрнийн философиийг дорнын философиийн үзэл санаагаар харахыг тэрээр чухалчлан үзсэний зэрэгцээ өөрөө үлгэрлэн философиийн үзэл баримтлалаа боловсруулсан байдаг.

Эхэн үедээ Нишида Китаро, Фүкузава Юкичи зэрэг сэтгэгчид өрнийн либерал ардчилсан үзэл суртлыг хүлээн авч, шинэчлэл өрнөжих үйл явцыг дэмжиж байсан нь үндэсний ёс заншлын хүчтэй эсэргүүцэлтэй эхэн үедээ тулгарсан юм. Тэд “өөрсдийн соёлыг дээшлүүлэхийн тулд өрсөлдөгч соёлоо мэддэг байх” тухай үзлээ эрхлэн гаргадаг сониноороо дамжуулан илэрхийлсээр байсан хэдий ч консерватив үзэлтнүүд хуучин амьдралын хэв маяг, зан заншлыг хэвээр нь авч үлдэн үргэлжүүлэхийг идэвхтэйгээр сурталчилж байсан. Жишээ нь, мэйжийн шинэчлэлийн үеийн улс төрч, нийгмийн зүтгэлтэн Такамори Сайго гадаад өртөнцийг эсэргүүцэж, “самурайн сэтгэл”-ийг магтан, түүнийг бишрэн шүтэх үзлийн номлож байснаараа алдартай юм. Тэрээр нийгмийн шинэчлэлийг хүлээн зөвшөөрч байсан хэдий ч энэ үйл явдал нь өрнийн соёлын нөлөөлөөр хийгдэхийн эсрэг тэмцэж, улмаар үндэсний хөдөлгөөнийг байгуулж түүнийгээ тэргүүлж байсан билээ.

Энэ өөрчлөлтийн он жилүүдэд япон дахь буддист үзэл санаа шинэчлэгдэх чиг хандлагатай болсон. Мөн тэр үед японд уламжлалт үндэсний үзэл санааг агуулсан, түүнд тулгуурласан урлагийн шинэлэг төрлүүд үүсэн бий болж байсан нь уг өөрчлөлт шинэчлэл дан ганц нийгмийн амьдралд төдийгүй урлаг соёл, боловсролын үйл ажиллагаанд ч нөлөөлж байсны илрэл юм.

Тухайн үед япончууд соён гэгээрүүлэгч Шозон Сакумагийн “Дорнын ёс суртахуун ба барууны

3. Фүкузава Юкичи /1834-1901/ Мэйжигийн үеийн их соён гэгээрүүлэгч, сэтгэгч. Кэй-Оогийн их сургуулийг үндэслэгч. Өрнөдийн соёлыг извтархий мэджэ ойлгосон хүн байжээ.

4. Robert E. Carter. 1995. Nothingness Beyond God: An Introduction to the Philosophy of Nishida Kitaro. 3 pp

техник” гэсэн үзэл баримтлалыг нь тэр үеийн сэхээтийүүд баримталж байв.

Нийгмийн өөрчлөлт шинэчлэлийн энэ цаг үед японы орчин үеийн философиийн үзэл санаа шинэ агуулгаар бүрэлдэн бий болсон гэж хэлж болно. Күнзийн сургаал болон буддизмын үзлийг бус, өрнийн философиийг чухалчлах болсны учир юу вэ? Эхэн үедээ японы сэтгэгчид өрнийн философичдийн тайлбар дээр л төвлөрч байсан. Гэсэн хэдий ч тэд өрнийн рационалист үзэл болон японы уламжлалт үзэл баримтлалын хооронд хурцадмал байдал үүссэн байна. Нишида Китаро европын философиийн сэтгэлгээнд “өриө дахин” бол “өргөнцийг төлөөлж”, өрнийн философи нь ихэвчлэн рационал танин мэдэхүйг чухалчилсан байдаг нь өрөөсгөл хэмээн шүүмжилжээ. Улмаар тэрээр өрнийн хийгээд дорнын соёлыг тэнцүү хэмжээнд үнэлхэх ёстой хэмээн үзэж байжээ.

Тэрээр дорнын соёлын иолоог дээшлүүлэхийн чухлыг өөрийн үндэсний үзлээрээ дамжуулж тайлбарлахыг хичээсэн. Ингэх гол шалтгааныг дорнын соёл бол хүний дотоод өртөнц рүү хандсан хүмүүнлэг соёл тул энэ соёлын иолоог дээшлүүлэх нь ирээдүйд чухал болохыг тэрээр онцолжээ. Нишида Китаро улс орны хөгжилд үндэсний үзлийн ач холбогдлын талаар хэлэхдээ: “Бид харанхуй бүдүүлэг байдлаасаа салсан, илүү хүчирхэг болно, учир нь япончууд үндэсний үзлээ ямагт дээдэлдэг” гэжээ.<sup>37</sup>

Японы үндэсний үзлийн нэг гол эх сурвалж нь самурайн философи буюу бүшид юм. Үүний мөн чанар нь амин хувиа хичээхгүй байх, өөрийгөө золиослох гэх мэт өнөөгийн ойлголтоор бол үндэстэндээ үйлчлэхийг сургасан агуулгатай. Жишээ нь, тэд арилжаа наймаа хийхийг ашиг олох, түншүүдийн хоорондын харилцаа нэмэгдэх гэхээсээ илүү ✓

- үндэсний хүчийг нэмэгдүүлэх;
- ноёрхлоо бататгах;
- өрсөлдөгчөө ялах;
- хариуцлагыг дээшлүүлэх гэсэн өргөн утгаар авч үздэг.

Тиймдээ ч өнөөдөр япончууд урьд урьдаас илүү хүчирхэг болсон байна. Энэ нь түүний үндэсний үзлийн орчин үеийн ач холбогдлыг харуулж байгаа хэрэг юм.

Нишида Китаро “үндэсний үзлийн дархлаа сурлах, сүл дорой байдлын нэг хэлбэр бол ард түмэндээ сэтгэл ханамжгүй байх явдал” хэмээн үзсэн нь түүний философи дахь үндэсний үзлийн агуулгын гол санаа болно. Эв нэгдэлгүй, хариуцлагагүй байх явдал бол үндэсний үзлийн дайсан гэж тэрээр үзсэн буй. Энэ нь өнөөгийн бидний амьдралын бие биеэ үгүйсгэсэн, үл ойшоосон байдлыг хэлсэн мэт. Японы соён гэгээрүүлэгч Фүкүзава Юкичи “Гадаадынхан манай улсад өөрийн хүссэнээр бизнес хийх, худалдаа хийх эрхтэй байхад бид залхуу хойрго байвал бидний үүрэг хариуцлага эсрэгээрээ эргэх болно”<sup>38</sup> хэмээн сануулсан байдаг.

Түүний хэлсэн үгний утга гүн агаад өнөөдөр бидэнд тохиолдож буй бодит асуудлыг хөнджээ. Бид хойч үеэ бус зөвхөн өөрийгөө, амин хувиа хичээх нь их байх юм бол манай улсад бизнес эрхэлж буй гадаадынхан баян тансаг амьдарч, эх нутаг руугаа баялгийг мөнгө болгон авч явна. Бидэнд харамсах сэтгэлээс өөр зүйл үлдэхгүй. Энэ байдлыг засах арга бол тэдний боловсруулсан “Дотроо эвтэй, гаднаа өрсөлдөөнч” хэмээх зарчим байж болох юм. Нишида Китаро, Фүкүзава Юкичи нар өрнийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх, улмаар тэднээс суралцаа талаар япончууд идэвхтэй байхыг тэрээр сайтар сурталчилдаг байжээ.

#### Үргэлжлэл бий

